



МОНГОЛ УИХ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сэрлийн гудамж 41, Утас: 7011 0251, Факс: (976) 7011 2400
E-mail: comcor@laas.mn, http: /laas.mn

2020 04 07 № 03/4084
Таны
Таны


“КИА МОТОРС МОНГОЛ” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.БАТЗОРИГ ТАНАА

Таны ирүүлсэн 2020 оны 04 дүгээр сарын
01-ний өдрийн к-73 дугаартай албан бичигтэй
танилцлаа.

Авлигатай тэмцэх газрын албан хэрэгцээнд
суудлын автомашин бэлтгэн нийлүүлэх
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Тендерийн
баримт бичгийн Тендерт оролцогчид өгөх
зааварчилгааны 21.6-д “Тендер нь шалгараагүй
оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан
тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт
багтаан хүчингүй болгоно” гэж заасан.

Өөрөөр хэлбэл тендерийн баталгаа нь 2020
оны 06 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хүчинтэй
байхаар тендерийн баримт бичигт тусгагдсан
болохыг үүгээр хүргүүлэв.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

 З.БААСАННЯМ

C:\DOCUMENTS\ALBAN.BICHIG\A5

0001576

КИА МОТОРС МОНГОЛ ХХК

Хаяг: Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо, 12-р хороолол,
Токиогийн гудамж-23, И-март Чингис хайпермаркетын 3 давхарт
Киа моторс төв

Утас: 976-90061218
Факс: 976-70147072

И-мэйл: info@kmm.mn
Вэб хуудас: www.kia.com

2020-04-01

-ны №

К-73

Тодруулга авах тухай

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тус газраас зарласан “Авлигатай Тэмцэх Газрын хэрэгцээнд автомашин бэлтгэн нийлүүлэх” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах АТГ/202011005 тоот тендерийн хүчинтэй байх хугацааг 45 /дөчин тав/ хоног мөн тендерийн баталгааны хүчинтэй байх хугацааг тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 45 /дөчин тав/ хоногоор заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр тендерийн хүчинтэй байх хугацааг 30 хоног, тендерийн баталгааны хүчинтэй байх хугацааг тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног гэж өөрчилсөн байна.

Иймд АТГ/202011005 тоот тендерийн баталгааны хүчинтэй хугацаан дээр тодруулга хийж өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А. БАТЗОРИГ

